



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 01/2023  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

МӨРӨН ХОТ ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.МӨНХ-ЭРДЭНЭ  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалж өр төлбөр их хэмжээгээр үүсч үндсэн үйл ажиллагаа болох айл өрхийн хог тээвэрлэлтийн үйл ажиллагаа түр зогсож хүндрэл үүссэн ба оны эцэст Аймгийн Засаг даргын 2022 оны А/440 дүгээр захирамжаар 271,277.0 мянган төгрөг олгож нийгмийн даатгалын 136,865.6 мянган төгрөг, шатахууны 134,413.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

### Аудитын гол асуудал

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогт тохирохгүй байгаа ба нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,048.1 сая төгрөгийн алдааг залруулж анхан шатны баримтын бүрдэл дутуу 29.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/07/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaafara@audit.gov.mn">erdenebaafara@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a> Ахлах аудитор Б. Давааням Утас: 88095496 Цахим хаяг: <a href="mailto:@audit.gov.mn">@audit.gov.mn</a> Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн Захирал: Б.Мядагмаа Утас: 99389208 Цахим хаяг: <a href="mailto:b_myadagmaaa@yahoo.com">b_myadagmaaa@yahoo.com</a> Аудитор Д.Оюундаваа Утас 99389692 Цахим хаяг: <a href="mailto:Oyuna_60@yahoo.com">Oyuna_60@yahoo.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал.....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....</b>	<b>6</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>9</b>
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
.....	14
4.6 Балансын дараах үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>14</b>
5.2 Зөвлөмж.....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 51/АЭЭЛӨНЗГ/ХАА-2023/07  
/НА-17А - 7ШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 146 мэдээлэл байршуулахаас 5 сая төгрөгөөс дээш 1,636,051,200 (нэг тэрбум зургаан зуун гучин зургаан сая тавин нэг мянган хоёр зуун ) төгрөгийн 37 орлогын гүйлгээ, 494,480.800 (дөрвөн зуун ерэн дөрвөн сая дөрвөн зуун наян мянга найман зуун) төгрөгийн 32 зарлагын гүйлгээ болон зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл, санхүүгийн тайлан, өмнөх аудитын дүгнэлт нийт 2,130,532,000 ( хоёр тэрбум нэг зуун гучин сая таван зуун гучин хоёр мянган) төгрөгийн 83 мэдээллийг огт байршуулаагүй байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журмын 4.1.2 "төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинд жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар", 4.1.3 "дараа жилийн зорилтот түвшинд жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар", 4.1.9 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 4.1.11 "хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор цахимаар" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн захирал С.Мөнх-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Мягмаржаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ



<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,727,291.17	48,065,926.62
1.1.2	Дансны авлага	36,119,909.00	18,414,083.00
1.1.4	Бусад авлага	0.00	432,335.00
1.1.6	Бараа материал	62,875,806.00	99,107,113.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал	1,300,000.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	105,023,006.17	166,019,458.44
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,613,314,015.26	4,970,028,977.83
1.2.2	Биет бус хөрөнгө	896,289.01	8,751,600.15
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,614,210,304.27	4,978,780,577.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,719,233,310.44	5,144,800,036.42
2.1.1.1	Дансны өглөг	4,912,800.00	7,310,398.95
2.1.1.2	Цалингийн өглөг	448,600.00	751,200.00
2.1.1.3	Татварын өр	33,283,612.74	71,337,382.78
2.1.1.4	НДШ - ийн өглөг	122,981,201.81	3,174,423.64
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	15,600.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	161,626,214.55	82,589,005.37
2.2	Өр төлбөрийн нийт дүн	161,626,214.55	82,589,005.37
2.3	Эздийн өмч	6,772,480,793.00	6,772,480,793.00
2.3.1	Төрийн	6,772,480,793.00	6,772,480,793.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,492,515,793.17	2,492,515,793.17
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,705,270,529.02	5,445,523,894.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-9,412,660,019.30	-9,648,309,449.14
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,557,607,095.89	5,062,211,031.05
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,719,233,310.44	5,144,800,036.42

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,195,367,503.99	1,807,262,458.00
3	Нийт ашиг ( алдагдал)	1,195,367,503.99	1,807,262,458.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,560,542,448.87	2,041,367,220.87
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-21,641,355.44	-1,544,666.97
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-386,816,300.32	-235,649,429.84
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-386,816,300.32	-235,649,429.84
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-386,816,300.32	-235,649,429.84



**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

төгрөгөөр

	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	6,772,480,793.00	2,492,515,793.17	4,705,270,529.02	-9,412,660,019.3	4,557,607,095.89
Залруулсан үлдэгдэл	6,772,480,793.00	2,492,515,793.17	4,705,270,529.02	-9,412,660,019.3	4,557,607,095.89
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	6,772,480,793.00	2,492,515,793.17	4,705,270,529.02	-9,412,660,019.3	4,557,607,095.89
Залруулсан үлдэгдэл	6,772,480,793.00	2,492,515,793.17	4,705,270,529.02	-9,412,660,019.3	4,557,607,095.89
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-235,649,429.84	-235,649,429.84
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	740,253,365.00	0.00	740,253,365.00
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	6,772,480,793.00	2,492,515,793.17	5,445,523,894.02	-9,648,309,449.14	5,062,211,031.05

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,205,281,503.99</b>	<b>1,732,847,284.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	171,382,280.00	1,732,847,284.00
1.1.2	Татаас, санхүүжилтийн орлого	1,019,580,600.00	0.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	14,318,623.99	0.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,201,601,471.75</b>	<b>1,689,508,648.55</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	528,760,157.00	602,523,330.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,000,000.00	302,759,416.72
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	479,025,277.39	88,638,311.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	29,049,422.95	115,458,456.35
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,270,000.00	463,817,810.86
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	32,341,025.41	12,198,017.91
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	1,993,500.00	3,102,462.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	45,162,089.00	101,010,842.79
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,740,032.24</b>	<b>43,338,635.45</b>
<b>4.1</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,740,032.24</b>	<b>43,338,635.45</b>

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	987,258.93	4,727,291.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,727,291.17	48,065,926.62

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Дансны нэр	Бизнес төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орон нутгийн төсвийн санхүүжилт	996,873,800.00	1,022,090,200.00	25,216,400.00	102.5
2	Тодотголын орлого	270,643,416.00	371,277,005.00	100,633,589.00	137.2
3	Чингүүнжавын талбайн болон бусад талбайн түрээс	3,375,000.00	8,705,500.00	5,330,500.00	257.9
4	Автобусны орлого	11,402,000.00	19,492,200.00	8,090,200.00	171.0
5	Хаяг рекламн самбарын орлого	4,740,000.00	6,174,040.00	1,434,040.00	130.3
6	Машин механизм түрээсийн орлого	62,698,022.00	11,826,700.00	(50,871,322.00)	18.9
7	Ногоон байгууламжийн орлого	6,605,000.00	58,794,446.00	52,189,446.00	890.2
8	Хөгжлийн сангийн санхүүжилт	135,503,000.00	135,503,000.00	-	100.0
9	Ус хүргэх үйлчилгээний орлого	6,000,000.00	3,375,000.00	(2,625,000.00)	56.3
10	Тоглоомын орлого	14,000,000.00	47,741,766.00	33,741,766.00	341.0
11	Чулууны үйлдвэрийн орлого	65,300,000.00	2,350,000.00	(62,950,000.00)	3.6
12	Бусад орлого		27,862,601.00	27,862,601.00	
13	Үнэ төлбөргүй нийлүүлсэн бараа материалын орлого		92,070,000.00	92,070,000.00	
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>1,577,140,238.00</b>	<b>1,807,262,458.00</b>	<b>230,122,220.00</b>	<b>114.6</b>
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,082,900.00	735,142,950.38	-19,939,949.62	97.4
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,385,350.00	99,624,337.04	5,238,987.04	105.6
3	Гэрэл цахилгааны зардал	23,955,898.50	23,955,898.50	0.00	100.0
4	Бичиг хэргийн зардал	3,871,500.00	4,549,674.99	678,174.99	117.5
5	Шуудан холбооны зардал	1,900,096.00	2,607,959.54	707,863.54	137.3
6	Мэргэжлийн үйлчилгээний зардал	0.00	9,158,700.00	9,158,700.00	
7	Даатгалын зардал	2,406,180.00	3,102,462.00	696,282.00	128.9
8	Түлш халаалт зардал	15,730,797.00	15,730,671.00	-126.00	100.0
9	Хөдөлмөр хамгаалал	33,371,840.00	22,874,030.49	-10,497,809.51	68.5
10	Элэгдэл, хорогдлын зардал		379,543,924.32		
11	Ариутгал цэвэрлэгээ	1,069,701.00	300,297.43	-769,403.57	28.1
12	Цэвэр бохир ус зардал	954,000.00	24,000.00	-930,000.00	2.5
13	Тээвэр шатахууны зардал	391,143,801.00	372,995,051.12	-18,148,749.88	95.4
15	Сэлбэгийн зардал	70,790,500.00	71,142,799.35	352,299.35	100.5
16	Бусад хангамжийн материалын зардал	34,698,500.00	171,483,504.37	136,785,004.37	494.2
17	Албан татвар төлбөр хураамжийн зардал	4,466,925.00	8,193,167.00	3,726,242.00	183.4
18	Банкны шимтгэлийн зардал	0.00	119,750.00	119,750.00	

19	Бусад зардал	48,111,774.00	7,771,385.00	-40,340,389.00	16.2
20	Багаж , хэрэгсэл	16,720,500.00	413,817.24	-16,306,682.76	2.5
22	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	0.00	9,558,700.00	9,558,700.00	
23	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн зардал	71,629,975.50	84,057,541.10	12,427,565.60	117.3
24	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	6,850,000.00	19,016,600.00	12,166,600.00	277.6
	<b>Нийт зардлын дүн</b>	<b>1,577,140,238.00</b>	<b>2,041,367,220.87</b>	<b>464,226,982.87</b>	<b>129.4</b>
25	Үндсэн хөрөнгө акталсны гарз		-1,544,666.97		
26	<b>Нийт ашиг алдагдал</b>		<b>-235,649,429.84</b>		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв , түүний үйл ажиллагаа зорилго зорилтын талаар

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигч нь Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна.

Тус байгууллагын эрхэм зорилго нь "Мөрөн сумын иргэд оршин суугчдын ажиллаж амьдрах тав тухтай орчин нөхцөл бүрдүүлэхийн төлөө шуурхай үйлчилгээ хүргэж , эрүүл аюулгүй, ногоон хотыг бүтээхэд хувь нэмэр оруулахад оршино" гэж тодорхойлжээ

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мөрөн сумын айл өрх албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог хаягдал зайлуулах, төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг эрхлэх
- Хог хаягдлыг хөрсөөр дарж булах, ариутгах халдваргүйжүүлэх, хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулж
- Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг угаах, цэвэрлэх
- Нийтийн бие засах газрын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах
- Мөрөн сумын нийтийн тээврийн үйлчилгээ зохион байгуулах
- Эзэнгүй муур нохой устгах  
Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмж өөрчлөлт оруулаагүй дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:
- чулууны үйлдвэрлэл
- ногоон байгууламжийн арчилгаа эрхлэх
- Мөрөн сумын гудамж талбайн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК нь 19,189 тонн хог хаягдал зайлуулж, 24,188 тн хог түрж булж, 187,254 м.кв ногоон байгууламжийн арчилгаа цэцэрлэгжүүлэлт хийж, 1,024 эзэнгүй нохой муур устгаж, гудамж талбайн гэрэлтүүлэг 95 хувьтай, 9,407м.кв авто болон явган хүний зам талбайн цэвэрлэгээг хариуцан ажилласан байна.

#### 3.2 Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн гадаад, дотоод орчин

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК нь Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.

2. Төрийн ба орон нутгийн өмчит компанид ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны 17 дугаар тогтоолоор компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байгуулсан ба 2022 оны 5 дугаар сарын 13-ны анхны хурлаар ТУЗ-ын дарга, нарийн бичгийн даргыг сонгон томилсон байна.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн дотоод хяналтын нэгжийн бүтцийг компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/13 тушаалаар баталсан нэгж зохион байгуулж тайлант онд 7 ажил зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажилласан байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2019 онд компанийн зохион байгуулалтад орсон үеэс мөрдөгдөж байгаа ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа боловч одоогийн үйл ажиллагаа олон чиглэлтэй болсон байгаа нөхцөлд орлого өртөг зардлыг тооцох шаардлагатай тул нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн өөрчлөх шаардлагатай болсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж Смарт ложик ХХК-ээс нягтлан бодох бүртгэлийн Смарт программыг 2022 онд 7,350.0 мянган төгрөгөөр худалдан авч нягтлан бодох бүртгэлдээ ашиглаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 425,566.7 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,727.3	48,065.9	43,338.6

Авлага	36,119.9	18,414.0	-17,705.9
Бараа материал	62,875.8	99,107.1	36,231.3
Урьдчилж төлсөн зардал	1,300.0	0,00	0,00
Үндсэн хөрөнгө	4,614,210.3	4,978,780.5	364,570.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,719,233.3</b>	<b>5,144,800.0</b>	<b>425,566.7</b>
Өр төлбөр	161,626.2	82,589.0	-79,037.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,772,480.7	6,772,480.8	0.00
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,719,233.3</b>	<b>5,144,800.0</b>	<b>425,566.7</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 48,065.9 мянган төгрөг үлдэж өмнөх оноос 43,338.6 мянган төгрөгөөр өссөн нь Мөрөн сумаас гэрээний дагуу олгосон санхүүжилтийн орлогын үлдэгдэл байна.

Авлага өмнөх оноос 17,705.9 мянган төгрөгөөр буурсан ба оны эцсийн 18,414.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл нь Галт сумын ЗДТГ-тай холбоотой 10,526.1 мянган төгрөг, иргэн Б.Нямдоржоос авах 4,594.7 мянган төгрөг, байгууллагуудад тараасан мод, сөөг, цэцгийн үнэ 3,293.2 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын үлдэгдэл 36,231.3 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө 364,570.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

1. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн зам талбай цэвэрлэх машин, хог хаягдлын чингэлэг, гэрэлтүүлгийн өргөгчтэй машин, хог тээвэрлэх машин зэрэг 727,658.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, өөрийн хөрөнгөөр 18,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж бүгд 745,658.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн.
2. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 05 дугаар тогтоолоор багш хөгжлийн баруун талын 200,050.9 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомуудыг Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газарт балансаас баланс-д шилжүүлсэн ба 22,352.0 мянган төгрөгийн тоглоомыг акталж хассан, элэгдлийн зардал 379,543.9 мянган төгрөгөөр байгуулсан нь тус тус нөлөөлсөн байна.

Өглөг өмнөх оноос 79,037.2 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг төлөгдсөн ба оны эцэст татварын өглөг 71,337.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 3,174.4 мянган төгрөгийн, байгууллага иргэнтэй холбоотой 7310.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг баталсан байна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 төлөвлөгөө	2022 гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Хог зайлуулалт	тн	19,189.00	19,189.00	0.00	100
2	Гэрэлтүүлэг	Асалтын хувь	96	95	-1.00	99.0

3	Гудамж талбайн цэвэрлэгээ	м2	9,407	9,407	0.00	100.0
4	Ногоон байгууламжийн арчилгаа, цэцэрлэгжүүлэлт	м2	187,254	202,554	15,300.0	108.2
5	Түрж булах	тн	24,189	24,189	0.0	100.0
6	Золбин нохой устгал	ш	824	1,024	200.0	124.3
7	Борлуулалтын орлого	мян.төг	1,577,140.2	1,807,262.4	230,122.2	114.6
8	Нийт зардал	мян.төг	1577,140.2	2,041,367.2	464,227.2	104.5
	Үйл ажиллагааны ашиг алдагдал	мян.төг	0.00	-235,649.4	0.00	0.00

Тайлант оны нийт орлогыг 1,577,140.1 мянган төгрөгөөр нийт зардлыг 1,577,140.1 мянган төгрөгөөр баталсан байна. Зардлын дүнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцогдож төлөвлөгдөөгүй байна.

Гүйцэтгэлээр 1,807,262.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,041,367.2 мянган төгрөгийн зардал гарган, 234,104.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна

Нийт орлогын гүйцэтгэл 1,807,262.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 230,122.2 төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдсэн нь төлөвлөгөөнд тусгаагүй дараах орлогууд нөлөөлсөн байна. Үүнд: Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 100,000.0 мянган төгрөг олгосон болон өөрийн үйл ажиллагааны орлого 12,835.8 мянган төгрөгөөр давсан, Мөрөн сумын санхүүжилт 25,216.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс илүү олгосон болон үнэ төлбөргүй 92,070.0 мянган төгрөгийн хангамжийн материал нийлүүлсэн нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 2,041,367.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 464,227.2 мянган төгрөгөөр илүү байгаа нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 379,543.9 мянган төгрөг/төлөвлөгөөнд тусгаагүй/ болон хангамжийн материалд үнэ төлбөргүй хүлээн авсан 92,070.0 мянган төгрөгийн зам талбайн цэвэрлэгээний ба гэрэлтүүлгийн материалын зарцуулалт нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 235,649.4 мянган төгрөг болсонд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал /төлөвлөгөөнд тусгаагүй /нөлөөлжээ.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн аудитор Д.Оюундаваа гүйцэтгэж, захирал ахлах аудитор Б.Мядагмаа анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК нь 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 53 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,582,183.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 31,673.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, орон тоо чиг үүрэг, бараа материалын нөөц, цахилгаан дулаан цэвэр ус, бичиг хэрэг тээвэр шатахуун гар утасны зардал, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 35 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 29-ний хурлаар бүтэц орон тоог шинэчлэн баталж үндсэн 88, гэрээт 11 нийт 99 орон тоотой байсныг үндсэн 8, гэрээт 11 орон тоог цомхотгож 2023 онд 80 орон тоотойгоор ажиллахаар баталсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн данс цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын цэсийг өмнөх онууд болон тайлант онуудад сонгож нээгээгүй байна.

Тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 1,636,051.2 мянган төгрөгийн 37 орлогын, 494,480.8 мянган төгрөгийн 32 зарлагын гүйлгээ болон зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл, санхүүгийн тайлан, өмнөх аудитын дүгнэлт, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын нийт 2,130,532.0 мянган төгрөгийн 83 мэдээлэл огт мэдээлэгдээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байх тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК компани нь үйл ажиллагаандаа ТУЗ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 29-ны 07 дугаар тогтоолоор баталсан дотоод журмыг мөрдөн ажиллаж байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийж үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3 асуудлуудыг асуудлын бүртгэлээр танилцуулсан. Үүнээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 49,000.0 мянган төгрөгийн залруулгыг жилийн эцсийн санхүүгийн тайланд зардал бууруулж буруу залруулсан байгааг дахин залруулга хийлээ.

Байгууллагын түлш шатахууны өр их хэмжээгээр үүсч үндсэн үйл ажиллагаа болох айл өрхийн хог тээвэрлэлтийн үйл ажиллагаа хэвийн явагдахгүй доголдсон байсныг Аймгийн Засаг даргын 2022 оны А/440 дүгээр захирамжаар 271,277.0 мянган төгрөг олгож нийгмийн даатгалын 136,865.6 мянган төгрөг, шатахууны 134,413.3 мянган төгрөгийн өр төлбөр барагдуулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага 1, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	80,100.0	1	80,100.0	100.0
Зөвлөмж	4	822,800.0	3	222,500.0	27.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>902,900.0</b>	<b>4</b>	<b>302,600.0</b>	<b>80</b>

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэл, программ хангамжтай холбоотой 4 зөвлөмж өгснөөс үнийн дүнгүй 3 зөвлөмжийг биелүүлж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмжийг дутуу биелүүлсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг 80 хувь биелсэн гэж үзлээ.

#### 4.6 Балансын дараах үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 13 дугаар хуралдааны 14 дүгээр тогтоолоор 1 сарын хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчилж айл өрх 9,900 төгрөг, албан байгууллагыг 10,000-40,000 төгрөгөөр тогтоож захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6095 дугаарт бүртгүүлсэн байна.
2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 05 дугаар тогтоолоор тоглоомын талбайн 4,78.2 м.кв 101,965.0 мянган төгрөгийн газрыг Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газарт шилжүүлэхээр шийдвэр гарсан боловч Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-д уг газар бүртгэлгүй, шилжүүлээгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,207,872.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,048,069.7 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн данстай холбоотой 2,130,532.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, дахин давтан гаргахгүй байх 29,270.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

##### Залруулсан алдаа:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



1. Аймгийн болон Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сан болон замын сангаас нийлүүлсэн 92,070.0 мянган төгрөгийг замын цэвэрлэгээний бодис болон гудамжны гэрэлтүүлгийн засварын материалыг санхүүгийн тайланд бусад орлогоор бүртгээгүй, зардал бууруулан бүртгэснийг залруулсан
2. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангаас нийлүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн 2 Эко нойлыг биет бус хөрөнгөөр бүртгэснийг залруулсан
3. Үндсэн хөрөнгийн тодруулгад нийт нэмэгдсэн 735,948.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авснаар, үнэ төлбөргүй шилжүүлсэн 200,050.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаар илэрхийлснийг залруулсан .

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### **5.2 Албан шаардлага**

##### Илрүүлсэн нь

Шилэн данс цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүгийн тайлан , 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын цэсийг өмнөх онууд болон тайлант онуудад сонгож нээгээгүй байна.

Тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 1,636,051.2 мянган төгрөгийн 37 орлогын, 494,480.8 мянган төгрөгийн 32 зарлагын гүйлгээ болон зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл, санхүүгийн тайлан, өмнөх аудитын дүгнэлт, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтын нийт 2,130,532.0 мянган төгрөгийн 83 мэдээлэл огт мэдээлэгдээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалт болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журмын 4.1.2, 4.1.3, 4.1.9, 4.1.11 заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

#### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний тайлан болон бараа материалын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалын зарцуулалтын анхан шатны баримт бүрдэл бүрэн бус 29,270.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг дагаж мөрдөөгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн газарт хөтлөгдөх нэг хэвийн маягтын дагуу анхан шатны баримтыг бүрэн хөтөлж хэвших

#### **2. Бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь товч зохиогдсон, өрлөгийг тодорхой зүйл ангиар бүртгэх, өртөг зардлыг тооцох зэрэг байгууллагын онцлогт тохироогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусган шинэчлэн боловсруулан баталж мөрдөн ажиллах

**3. Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайлан гаргах тухай**

**Илрүүлэлт:**

Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай" журмын дагуу санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайлан гаргаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Компанийн санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайлан гаргаж тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Залруулсан алдаа	3	1,048,069.7			3	1,048,069.7	3	1,048,069.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,048,069.7</b>			<b>3</b>	<b>1,048,069.7</b>	<b>3</b>	<b>1,048,069.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/				
		Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын байгууллаг

									албан шаардлага		ад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой	3	29,270.9					3	29,270.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>29,270.9</b>					<b>1</b>	<b>29,270.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**  
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн данс цахим хуудсанд холбогдох мэдээллийг мэдээлээгүй	1	2,130,532.0					1	2,130,532.0	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,130,532.0</b>					<b>1</b>	<b>2,130,532.0</b>	